

## ДААТГАЛЫН МЭДЭЭ

2011 оны 6, 7 дугаар сар

### 1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2011 оны 6 дугаар сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон тусгай зөвшөөрөлд орсон өөрчлөлтүүд дараах байдалтай байна:

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2011-5 сар	/тоогоор/		
			Нэмэгдсэн	Хасагдсан	2011-6 сар
1	Даатгалын компани	17	1 <sup>1</sup>	1 <sup>2</sup>	17
2	Даатгалын компанийн салбар	149			149
3	Даатгалын төлөөлөгч	1838	330 <sup>3</sup>		2168
4	Даатгалын зуучлагч	9			9
5	Даатгалын хохирол үнэлэгч	7			7
6	Актуарч	12			12
7	Бусад		7 <sup>4</sup>		

Тайлант үед даатгалын компанийн салбар, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч, актуарчийн тоонд өөрчлөлт ороогүй байна.

<sup>1</sup>Хорооны 2011 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн 146 дугаар тогтоолоор “Мандал женерал” ХХК-д ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон;

<sup>2</sup>Хорооны 2011 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 173 дугаар тогтоолоор “Гранд даатгал” ХХК-ийг “Ард даатгал” ХХК-д нэгдэхийг зөвшөөрч, “Гранд даатгал” ХХК-ийн ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;

<sup>3</sup>Хорооны даргын 2011 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 101 дүгээр тушаалаар 242 иргэнд “Монгол даатгал” ХХК-ийн, 72 иргэнд “Миг даатгал” ХХК-ийн, 6 дугаар сарын 29-ний өдрийн 108 дугаар тушаалаар 16 иргэнд “Ард даатгал” ХХК-ийн даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус олгосон;

<sup>4</sup>Хорооны даргын 2011 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 97 дугаар тушаалаар “Гранд даатгал” ХХК-д хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүн, дүрмийн сангийн бүтэцдээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн;

<sup>4</sup>Хорооны 2011 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн 147 дугаар тогтоолоор “Соёмбо даатгал” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтныг, 148 дугаар тогтоолоор “УБ даатгал” ХХК-ийн

эрх бүхий албан тушаалтныг, 6 дугаар сарын 30-ны өдрийн 174 дүгээр тогтоолоор “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтныг, 175 дугаар тогтоолоор “Номин даатгал” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтныг томилохыг тус тус зөвшөөрсөн;

<sup>4</sup>Хорооны 2011 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн 149 дүгээр тогтоолоор “Миг даатгал” ХХК-д хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн;

<sup>4</sup>Хорооны 2011 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 176 дугаар тогтоолоор “Миг даатгал” ХХК-ийн 8 даатгалын төлөөлөгчийн, “Монгол даатгал” ХХК-ийн 168 даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 1 сарын хугацаагаар түдгэлзүүлсэн.

2011 оны 7 дугаар сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон тусгай зөвшөөрөлд орсон өөрчлөлтүүд дараах байдалтай байна:

/тоогоор/					
№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчид	2011-6 сар	Нэмэгдсэн	Хасагдсан	2011-7 сар
1	Даатгалын компани	17			17
2	Даатгалын компанийн салбар	149	1 <sup>1</sup>		150
3	Даатгалын төлөөлөгч	2168	50 <sup>2</sup>	176 <sup>3</sup>	2042
4	Даатгалын зуучлагч	9			9
5	Даатгалын хохирол үнэлэгч	7	1 <sup>4</sup>		8
6	Актуарч	12			12
7	Бусад		2 <sup>5</sup>		

Тайлант үед даатгалын компани, даатгалын зуучлагч, актуарчийн тоонд өөрчлөлт ороогүй байна.

<sup>1</sup>Хорооны даргын 2011 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 116 дугаар тушаалаар “Соёмбо даатгал” ХХК-д Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн нутагт 2 дахь салбараа нээн ажиллуулахыг зөвшөөрсөн;

<sup>2</sup>Хорооны даргын 2011 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 117 дугаар тушаалаар 10 иргэнд “Ард даатгал” ХХК-ийн, 7 дугаар сарын 27-ны өдрийн 121 дүгээр тушаалаар 40 иргэнд “Соёмбо даатгал” ХХК-ийн даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон;

<sup>3</sup>Хорооны 2011 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 213 дугаар тогтоолоор “Миг даатгал” ХХК-ийн 8, “Монгол лаатгал” ХХК-ийн 168 даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгосон;

<sup>4</sup>Хорооны 2011 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 211 дүгээр тогтоолоор “Жи эй си си” ХХК-д даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон;

<sup>5</sup>Хорооны 2011 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 210 дугаар тогтоолоор “Нэйшнл лайф даатгал” ХХК-д дүрмийн сангийн хэмжээгээ нэмэгдүүлэхийг зөвшөөрсөн;

<sup>5</sup>Хорооны 2011 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 212 дугаар тогтоолоор “Скай эрдэнэ” ХХК-ийн даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн.

## 2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2011 оны 6 дугаар сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг 2010 оны мөн үеийнхтэй харьцуулбал:

### Ердийн даатгалын компаниудын хувьд :

/төгрөгөөр/			
№	Үзүүлэлт	2010-6 сар	2011-6 сар


1	Даатгалын нийт хураамж	5,119,896,304.1	6,150,244,757.1
2	Олгосон нийт нөхөн төлбөр	417,340,949.0	656,282,229.7
3	Давхар даатгалд төлсөн хураамж	1,903,502,331.0	1,482,227,570.2
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэг/	11,423	20,190
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	280,881,591,000.0	17,666,106,000.0
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	41,276,100.0	35,000,000.0

2011 оны 6 дугаар сард даатгалын компаниудын төвлөрүүлсэн даатгалын нийт хураамжийн орлого нь өмнөх оны мөн үеийнхээс 1,030.3 сая төгрөгөөр, олгосон даатгалын нөхөн төлбөр 238.9 сая төгрөгөөр өсч, давхар даатгалд төлсөн хураамж 421.3 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2010-7 сар	2011-7 сар
1	Даатгалын нийт хураамж	2,231,675,654.9	2,710,418,990.5
2	Олгосон нийт нөхөн төлбөр	342,119,906.1	424,752,735.9
3	Давхар даатгалд төлсөн хураамж	924,815,304.0	543,596,785.1
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэг/	7,090	11,236
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	272,890,371,000.0	61,694,000,000.0
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	23,943,386.3	32,045,950.0

2011 оны 7 дугаар сард даатгалын компаниудын төвлөрүүлсэн даатгалын нийт хураамжийн орлого өмнөх оны мөн үеийнхээс 478.7 сая төгрөгөөр, олгосон даатгалын нөхөн төлбөр 82.6 сая төгрөгөөр тус тус өсч, давхар даатгалд төлсөн хураамж 381.2 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Харин өмнөх сараас даатгалын хураамжийн орлого 3,439.8 сая төгрөгөөр, даатгалын нөхөн төлбөр 231.5 сая төгрөгөөр, давхар даатгалд төлсөн хураамж 938.6 сая төгрөгөөр тус тус буурчээ.

Даатгалын компаниудын олсон нийт даатгалын хураамж болон олгосон даатгалын нөхөн төлбөрийн өсөлт, бууралтыг 2011 оны эхний 7 сарын байдлаар графикаар үзүүлье /сая төгрөгөөр/:



Даатгалын компаниудын 2011 оны 6 дугаар сард хийсэн нийт гэрээнүүдээс хамгийн өндөр даатгалын үнэлгээ бүхий гэрээ нь “Ард даатгал” ХХК-ийн “Юнител” ХХК-тай байгуулсан 17,666.1 сая төгрөгийн үнэлгээтэй хөрөнгийн даатгалын гэрээ, хамгийн их дүнтэй даатгалын нөхөн төлбөрийг “Номин даатгал” ХХК-иас “Экс экс и эм” ХХК-ийн тээврийн хэрэгслийн даатгалын гэрээний нөхөн төлбөрт 35.0 сая төгрөгийг олгосон, 7 дугаар сард хийсэн гэрээнүүдээс хамгийн өндөр даатгалын үнэлгээ бүхий гэрээ нь “Практикал даатгал” ХХК-ийн Иргэний нисэхийн ерөнхий газартай байгуулсан 38,490.2 сая төгрөгийн үнэлгээтэй хөрөнгийн даатгалын гэрээ, хамгийн их дүнтэй даатгалын нөхөн төлбөрийг “Монгол даатгал” ХХК-иас “Хурд авто” ХХК-ийн хүнд болон тусгай зориулалтын машин механизмын даатгалын гэрээний нөхөн төлбөрт 32.0 сая төгрөгийг олгосон байна.

**Урт хугацааны даатгалын компанийн хувьд :**


№	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2010-6 сар	2011-6 сар
1	Даатгалын нийт хураамж	8,677,339.0	27,105,131.8
2	Олгосон нийт нөхөн төлбөр	2,064,698.0	13,331,281.0
3	Давхар даатгалд төлсөн хураамж		
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо	3	48
	Үүнээс:-Хувь хүний хугацаат даатгалд	2	8
	-Байгууллагын хугацаат даатгалд	1	2
	-Өндөр хамгаалалттай ЭМД-д		2
	-Эмнэлгийн мөнгөний даатгалд		13
	-Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд		15
	-Тэтгэврийн даатгалд		8
	-Орон сууцны даатгалд		
	-Хуримтлалын даатгалд		
	-Зээлдэгчийн амь насны даатгалд		
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	10,000,000.0	376,035,000.0
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	220,000.0	5,000,000.0

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн 2011 оны 6 дугаар сарын даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийг 2010 оны мөн үеийнхтэй харьцуулбал даатгалын хураамжийн орлого 18.4 сая төгрөгөөр, даатгалын нөхөн төлбөр 11.3 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2010-7 сар	2011-7 сар
1	Даатгалын нийт хураамж	1,819,560.0	18,494,028.1
2	Олгосон нийт нөхөн төлбөр	2,454,910.0	2,813,600.0
3	Давхар даатгалд төлсөн хураамж		
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо	2	18
	Үүнээс:-Хувь хүний хугацаат даатгалд	2	5
	-Байгууллагын хугацаат даатгалд		2
	-Өндөр хамгаалалттай ЭМД-д		1
	-Эмнэлгийн мөнгөний даатгалд		2
	-Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд		4
	-Тэтгэврийн даатгалд		4
	-Орон сууцны даатгалд		
	-Хуримтлалын даатгалд		
	-Зээлдэгчийн амь насны даатгалд		
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	1,000,000.0	49,050,000.0
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	540,000.0	300,000.0

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн 2011 оны 7 дугаар сарын даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийг 2010 оны мөн үеийнхтэй харьцуулбал даатгалын хураамжийн орлого 16.7 сая төгрөгөөр, даатгалын нөхөн төлбөр 0.4 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн олсон даатгалын хураамж болон олгосон даатгалын нөхөн төлбөрийн өсөлт, бууралтыг 2011 оны эхний 7 сарын байдлаар графикаар үзүүлье /сая төгрөгөөр/:



**Даатгалын зуучлагч компаниудын хувьд :**

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/		
		2011-5 сар	2011-6 сар	2011-7 сар
1	Даатгуулагчаас шууд орж ирсэн даатгалын хураамж	94,822,540.8	39,713,401.4	30,521,004.9
2	Даатгалын зуучлагчийн орлого	35,469,420.0	30,623,310.1	20,426,011.2
3	Зуучилсан даатгалын гэрээний тоо	93	191	55
4	Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	3,000,000,000.0	248,000,000,000.0	248,000,000,000.0

2011 оны 7 дугаар сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд 55 даатгалын гэрээг даатгагчдад зуучлан 20.4 сая төгрөгийн зуучлалын орлого олсон байна. Даатгалын зуучлагч компаниудаас хамгийн өндөр үнэлгээний дүнтэй даатгалын гэрээ буюу 248,000.0 сая төгрөгийн үнэлгээтэй “Аэро Монголиа” ХХК болон “Моннис даатгал” ХХК-иудын хооронд байгуулсан агаарын хөлгийн даатгалын гэрээг AIG компанид давхар даатгуулахад “Монголиан интернэйшнл брокерс” ХХК зуучилсан байна.

**Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :**

№	Үзүүлэлт	/төгрөгөөр/		
		2011-5 сар	2011-6 сар	2011-7 сар
1	Даатгалын хохирол үнэлсэний орлого	4,173,500.0	3,438,727.3	3,192,818.2
2	Үнэлсэн даатгалын хохирлын тоо	211	217	111
3	Үнэлсэн даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн	16,591,000.0	58,213,625.0	80,258,000.0

2011 оны 7 дугаар сарын байдлаар даатгалын хохирол үнэлэгч компаниуд 111 даатгалын тохиолдлын хохирлыг үнэлж, 3.2 сая төгрөгийн даатгалын хохирол үнэлсэн орлоготой ажиллажээ.

**3. БУСАД**

Хорооны 2011 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 177 дугаар тогтоолоор Малын индексжүүлсэн даатгалыг санхүүгийн нэмэлт тайланд бүртгэх, тайлагнах түр зааврыг баталсан;

Хорооны даргын 2011 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 119 дүгээр тушаалаар Даатгалын бодлого, зохицуулалтын орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан.